

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 22 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 14.00 цагт эхэлж, 15.00 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дэд даргын албан тушаалд Ухнаагийн Отгонбаярыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яамны газрын дарга нарын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дотоод зохион байгуулалтын албаны даргын албан тушаалуудад тус тус томилогдох удирдах ажилтан нарт дүгнэлт гарган нэр дэвшүүлэх тухай	1.Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Дуламсүрэнгийн Давааг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Борбаатарт санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов. 2.Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Сэрээнэнгийн Энхболд, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Совдын Төгсдэлгэрийг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Хүрэлбаатарт санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов. 3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дотоод зохион байгуулалтын албаны даргын албан тушаалд Лхамжавын Батжавыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга С.Чинзоригт санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны газрын болон хэлтсийн даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтан нарт дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын газрын даргын албан тушаалд Бадгаагийн Ганбаатарыг, Мэдээлэл, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан тушаалд Эрдэнэсүрэнгийн Энхтайванг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч

	харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах тухай	агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг: Даргаар: Газрын дарга, гишүүдэд: Газрын орлогч дарга бөгөөд газрын харилцаа, хот байгуулалтын албаны дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Геодези, зураг зүйн хэлтсийн дарга, Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Барилга угсралтын технологи, материалын хэлтсийн дарга, Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга, Хот байгуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга) нарын 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
5	"Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-д өөрчлөлт оруулах тухай	1."Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах: "6.2.2.)энэхүү журмын 2.1.1-2.1.4-т заасан төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэлд байгаа болон мөн журмын 2.2.1-2.2.4-т заасан төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэлд байгаа иргэдээс тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг Төрийн албаны зөвлөлийн дарга болон орон тооны гишүүд, салбар зөвлөлд түүний дарга болон гишүүд сонгон холбогдох байгууллагад захиалгынх нь дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар дэвшүүлэх; 6.2.3.)энэхүү журмын 2.1.1-2.1.4-т заасан төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэлд байгаа болон мөн журмын 2.2.1-2.2.4-т заасан төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэлд байгаа иргэдээс тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа иргэдийн мөн журмын 1 буюу 2 дугаар хавсралтын дагуу гаргасан судалгааг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ. Хэрэв томилох эрх бүхий этгээд энэхүү судалгаанд орсон иргэдээс хэн нэгийг нь сонгон тухайн албан тушаалд томилох боломжтой гэж үзсэн тохиолдолд энэ тухай саналаа төрийн албаны төв байгууллага болон салбар зөвлөлд ирүүлэх бөгөөд харъяаллын дагуу Төрийн албаны зөвлөлийн дарга болон орон тооны гишүүд, салбар зөвлөлд түүний дарга болон гишүүд түүнийг нэр дэвшүүлэх, эсхүл дээрх судалгаанд орсон иргэний аль нэгийг нэр дэвшүүлэх тухай шийдвэр гаргах;" гэж өөрчлөхөөр МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хийсэн шалгалтын тухай танилцуулга	Танилцуулав.